



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.08.08 № 337

танай _____-ны № _____-т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, 37.10, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Архангай аймгийн аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох иргэн Цолмонгийн Цогтбаярын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого,

650230505

төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

“Цолмонгийн Цогтбаяр /РД:АК85040417/-ын Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Ц.Цогтбаяр бие даан нэр дэвшигч”-ийн мөрийн хөтөлбөр (...²... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: “Архангай аймгийн сонгуулийн хороо”-нд

Хавсралт ...²... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

Архангай аймгийн ИТХ-ын сонгуульд Цэнхэр сумаас, Цэнхэр сумын ИТХ-ын сонгуульд 6-р баг, Тамир багаас бие даан нэр дэвшигч Цолмонгийн Цогтбаярын 2024-2028 оны мөрийн хөтөлбөр

2024 оны 7 дугаар сарын 24

Зорилго: “Эрүүл, чийрэг, эрдэм боловсролтой, шударга иргэн ирээдүйн сайн сайхныг бүтээнэ” зорилгыг дэвшүүлж, иргэдийг төлөөлөн, тэдний дуу хоолой болж, түүчээлэн хэрэгжүүлж, сум, орон нутгаа хөгжүүлэх хөтөлбөрөө боловсрууллаа.

Нэг. Эрүүл мэнд

- Эрүүл амьдралын хэв маяг, амьдралын зөв дадал хэвшлийг бий болгох, танхимын болон онлайн сургалтыг дэмжин ажиллана.
- Байгалийн эко байдлыг түшиглэн чөлөөт цагаа эрүүл мэнддээ зарцуулах орчныг бүрдүүлнэ.
- Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэг, оношлоогоог идэвхжүүлэх, нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, зөвлөгөө өгөх ажлыг жил бүр эрүүл мэндийн төв болон бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- Архи, тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодис бусад төрлийн хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хор хохирлыг ухуулан таниулах ажлыг сайжруулна.
- Сэтгэл зүйн зөвөлгөө, тусламж, сэтгэл заслын үйлчилгээг хөгжүүлж, иргэдэд хүртээмжтэй болгоно.

Хоёр. Боловсрол, хүмүүжил, ёс суртахуун

- Сургуулийн өмнөх насны хүүхдүүд болон сурагчдын сургалтыг орчныг сайжруулах, чанаржуулах тал дээр хяналт тавьж ажиллана.
- Сургуулийн өмнөх насны хүүхдүүд болон сурагч, залуучуудад чиглэсэн, боловсрол, хүмүүжил, ёс, суртахуун, бие хүн болон төлөвших хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлнэ.
- Байгалийн эко орчин болон малчдын ахуй амьдралыг түшиглэн хүүхэд, залуучуудад амьдрах ухааны чадвар олгох хөдөлмөр зуслан байгуулах, санал санаачлаг гарган ажиллана.
- Сургалтын арга зүйг сайжруулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран багш, сурагч солилцооны хөтөлбөрийг дэмжих, сурагчдыг амралтын хугацаанд нь хичээлийн хоцрогдол арилгах, мэдлэг чадвараа дээшлүүлэхэд зориулж, сургалтын хөгжлийн төв байгуулахад анхаарч ажиллана.
- Бүх насны иргэдэд зориулсан, техник технологийн хөгжил, хувь хүний хөгжил, эрүүл мэндийн боловсрол, бизнес эрхлэлт, төсөл боловсруулах

зэрэг төрөл бүрийн сургалтуудыг мэргэшсэн байгууллагуудтай хамтран үе шаттайгаар зохион байгуулна.

Гурав. Хууль, эрх зүй, хүний эрх үүрэг

- Бүх шатанд хуулиа мэддэг, дээдэлдэг биелүүлдэг байх талд хяналт тавьж ажиллана.
- Хувь хүн, хуулийн этгээдийн эрхийг зөрчсөн аливаа үйлдлийг хуулийн хүрээнд шийддэг байхад хяналт тавьж ажиллах
- Төрийн албан хаагчдын өөртөө болон хамаарал бүхий хүмүүст давуу эрх олгодог аливаа үйлдлийг таслан зогсоох
- Хууль бусаар газар олгосон болон авлига өгсөн, авсан аливаа үйлдэлд хүлээх хариуцлагыг чангатгаж иргэдэд газрыг хуулийн дагуу өмчлөх, эзэмших эрхийг хангуулан ажиллана.
- Хууль эрх зүйн талаар зохих шатны байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулж ажиллана.

Дөрөв. Байгаль хамгаалал, аялал жуулчлал

- Экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулж байгаа хувь хүн, албан байгууллагуудад иргэдийн оролцоотой хяналт тавих ажлыг зохион байгуулна.
- Байгальд ээлтэй аялал жуулчлалыг дэмжин ажиллана.
- Устаж, ховордож буй ан, амьтан, ургамал, ой модыг нөхөн сэргээх, дахин нутагшуулах тал дээр анхаарч, зохих шатны байгууллагуудтай хамтран сургалт сурталчилгаа хийж ажиллана.
- Хөрсний бохирдлоос сэргийлэн, айл өрх, албан байгууллагуудыг байгальд ээлтэй бохирын системтэй болгох ажлыг эрчимжүүлж ажиллана.
- Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах тал дээр төсөл хөтөлбөр боловсруулж ажиллана.

6517143920
АЮА0052 9001034

Тав. Хөдөлмөр эрхлэлт, өрхийн амьжиргаа

- Иргэд, аж, ахуйн нэгжүүдийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд хяналт тавьж, хууль, журмыг биелүүлэхэд анхаарч ажиллана.
- Иргэдийн хөдөлмөр эрхлэх эрмэлзлийг дээшлүүлэх, чадваржуулах сургалтад хамруулах санал санаачлагыг гарган ажиллана.
- Малчдын амьжиргааны түвшнийг нэмэгдүүлэх аливаа төсөл хөтөлбөрийг дэмжих, малын үүлдэр угсааг сайжруулж, ашиг шимийг дээшлүүлэх, малын гаралтай түүхий эд, сүү, сүүн бүтээгдэхийн боловсруулахад шаардагдах техник тоног төхөөрөмжийг судлаж дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.
- Сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрийн зээл тусламжийг үр ашигтай зарцуулахад анхаарч, хяналт тавьж ажиллана.
- Ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор сум, орон нутагт жижиг дунд үйлдвэр байгуулах төсөл хөтөлбөр боловсруулах, санал санаачлагыг гарган ажиллана.

---oOo---